

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СЭА-2026/005/НА-СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.open.audit.mn">www.open.audit.mn</a> Сүхбаатар сум 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх Утас: 7036-3040 Цахим хаяг: <a href="mailto:batmunkhb@audit.gov.mn">batmunkhb@audit.gov.mn</a> Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 7036-3036 Цахим хаяг: <a href="mailto:otgonbayarts@audit.gov.mn">otgonbayarts@audit.gov.mn</a> Ахлах аудитор: С.Баасансүрэн Утас: 7036-2442 Цахим хаяг: <a href="mailto:baasansurens@audit.gov.mn">baasansurens@audit.gov.mn</a></p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗҮҮНБҮРЭН  
СУМЫН ЗАСАГ ДАРГА  
С.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

2026.03.20 № СА-2026/005/НА-ТА-ТТЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан зөрчил нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар болон санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын хүрээнд илэрсэн дараах зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, 15.1.5, 15.1.7, ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4, 31 дүгээр зүйлийн 31.1.2, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын 3, 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар"-ын 1, аймгийн ИТХ-ын 2014

3  
4326050342

оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 25 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1, сумын ИТХ-ын 2021 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 26 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот Илдэн бүрэн үйлдвэрийн газрын дүрэм”-ийн 7.1, 7.4, 7.5.4 дахь заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Зүүнбүрэн сумын ИТХ-ын нарийн бичгийн даргын 2025 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн А/40 дүгээр тушаалаар бараа үйлчилгээний бусад зардлаас ахмадын баярын арга хэмжээнд зориулж 320.0 мянган төгрөгийн 10 шил архи худалдан авсан.
- Сумын ЗДТГ нь Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн Б/18 дугаар захирамжаар ой хээрийн түймрийн үед ажилласан гэх үндэслэлээр тогтоосон хувь хэмжээнээс хэтрүүлэн, илүү цагийн хөлсөнд 4,053.8 мянган төгрөгийг илүү тооцож олгосон.
- Зүүнбүрэн сумын ИТХ-ын 2025 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 05 дугаар тогтоолоор баталсан “Илдэн бүрэн” ОНӨААТҮГ-ын бүтэц, орон тоонд батлагдаагүй цахилгаанчны ажлыг хавсран гүйцэтгүүлсэн гэх шалтгаанаар жолоочид үндсэн цалингийн 40 хувь буюу 4,400.0 мянган төгрөгийн нэмэгдлийг олгосон.
- “Илдэн бүрэн” ОНӨААТҮГ-ын захирлын 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/02 дугаар тушаалаар цагаан сарын баярыг тохиолдуулан байгууллагын нийт ажилтнуудад гарын бэлэг (хэвийн боов, сүү, чихэр) өгөхөд 2,538.0 мянган төгрөгийг зарцуулсан.
- Тайлант онд “Илдэн бүрэн” ОНӨААТҮГ нь шууд худалдан авах босго үнээс давсан 27,776.6 мянган төгрөгийн нүүрсний худалдан авах худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй.
- Үйлдвэрийн газрын үйл ажиллагааг зохистой удирдаагүй, санхүүгийн байдалд дүн шинжилгээ хийж, бодлого менежментийг зөв тогтоогоогүйгээс “Илдэн бүрэн” ОНӨААТҮГ нь 387,060.1 мянган төгрөгийн алдагдалтай ажиллаж, өөрөө өөрийгөө санхүүжүүлж чадахгүй байна.
- Аймгийн Орон нутгийн өмчийн газрын зөвшөөрөлгүйгээр “Илдэн бүрэн” ОНӨААТҮГ-ын захирал нь байгууллагын эзэмшлийн 120 кв талбай бүхий “Халуун ус”-ыг тус сумын иргэнд түрээслэхээр 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдөр гэрээ байгуулсан.
- Аймгийн ХХҮГ-аас хийсэн шалгалтаар 750.0 мянган төгрөгийн торгууль ногдуулсан бөгөөд зөрчил гаргасан тус ОНӨААТҮГ-ын захирал Д.Оюунсүрэнд хариуцлага тооцолгүйгээр байгууллагын хөрөнгөөс төлж, үр ашиггүй зардал гаргасан байна.

#### **Асуудлыг онцолсон тэмдэглэсэн хэсэг**

Зүүнбүрэн сумын ИТХ-ын 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн “2025 оны тодотгосон төсөв батлах тухай” 20 дугаар тогтоолоор 684,284.5 мянган төгрөгийн татварын орлого, 13,000.0 мянган төгрөгийн татварын бус орлого нийт **697,284.5** мянган төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас

гүйцэтгэлээр **719,671.2** мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 103.2 хувиар давуулан биелүүлсэн байна.

#### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар нийт 4 төсөл, арга хэмжээнд 250,000.0 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 228,871.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 21,129.0 мянган төгрөг хэмнэгдсэн байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд Зүүнбүрэн сумын Засаг дарга нь 4 зорилт, 123 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 85.5 хувийн биелэлттэй үнэлэгдсэн байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТМӨНХ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөг/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		646,839.4	732,503.6
2	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	487,859.7	493,680.6
3	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	33,592.0	44,856.6
4	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	125,387.8	193,966.4
5	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		3,546,801.1	3,112,139.3
6	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	3,546,801.1	3,112,139.3
7	Биет хөрөнгө		3,390,372.9	2,969,649.1
8	Биет бус хөрөнгө	13	156,428.2	142,490.2
<b>9</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2</b>		<b>4,193,640.4</b>	<b>3,844,642.9</b>
10	НИЙТ ӨР ТӨЛБӨР		1,043.6	26,408.4
11	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		1,043.6	26,408.4
12	Өглөг		1,043.6	26,408.4
13	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		4,192,596.9	3,818,234.5
14	Засгийн газрын хувь оролцоо		4,192,596.9	3,818,234.5
15	Засгийн газрын оруулсан капитал		297,811.3	297,811.3
16	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/		1,413,704.7	1,413,704.7
17	Хуримтлагдсан үр дүн		2,014,855.8	1,640,493.4
18	Өмнөх үеийн үр дүн		1,338,964.0	2,014,855.8
19	Тайлант оны үр дүн		675,891.7	(374,316.6)
20	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		466,225.1	466,225.1
<b>21</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5</b>		<b>4,193,640.4</b>	<b>3,844,642.9</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөг/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		3,235,482.8	2,768,647.4
2	ТАТВАРЫН ОРЛОГО		944,523.7	708,616.6
3	Орлогын албан татвар		543,603.6	520,967.0
4	Хувь хүний орлогын албан татвар		558,469.6	578,811.9
5	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		(14,866.0)	(57,844.9)
6	Хөрөнгийн албан татвар		169,260.4	119,278.6
7	Бусад татвар, төлбөр, хураамж		231,659.7	68,371.1
8	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	1,061,899.7	2,060,030.7
9	Тусламжийн орлого		-	1,131,733.7
10	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,229,059.5	-
<b>11</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2а, 2б</b>	<b>2,146,175.3</b>	<b>3,129,026.0</b>
12	УРСГАЛ ЗАРДАЛ		2,146,175.3	2,900,154.9
13	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		2,086,975.9	2,884,432.4
14	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		809,069.7	979,772.0
15	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		99,310.1	120,102.0
16	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		386,195.7	436,647.8

17	Хангамж, бараа материалын зардал		40,949.3	45,699.4
18	Эд хогшил, урсгал засварын зардал		25,501.3	32,142.1
19	Томилолт, зочны зардал		5,896.2	7,267.1
20	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		356,106.9	215,539.9
21	Бараа үйлчилгээний бусад зардал		363,946.9	1,047,262.2
<b>22</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>59,199.4</b>	<b>15,722.5</b>
23	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		-	228,871.0
24	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		1,089,307.5	(360,378.6)
25	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		413,415.7	13,938.0
26	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)		(413,415.7)	(13,938.0)
<b>27</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)</b>		<b>675,891.8</b>	<b>(374,316.6)</b>

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөг/

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,516,705.11		3,516,705.11
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,516,705.11		3,516,705.11
3	Тайлант үеийн үр дүн	675,891.75		675,891.75
<b>4</b>	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>4,192,596.86</b>		<b>4,192,596.86</b>
<b>5</b>	<b>2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>4,192,596.86</b>		<b>4,192,596.86</b>
6	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(45.78)		(45.78)
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,192,551.08		4,192,551.08
8	Тайлант үеийн үр дүн	(374,316.60)		(374,316.60)
<b>9</b>	<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>3,818,234.48</b>		<b>3,818,234.48</b>

### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөг/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,626,132.04	2,128,755.42
2	ТАТВАРЫН ОРЛОГО	944,523.72	708,616.64
3	Орлогын албан татвар	543,603.58	520,966.99
4	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(14,866.00)	(57,844.86)
5	Хөрөнгийн албан татвар	169,260.44	119,278.56
6	Бусад татвар, төлбөр, хураамж	231,659.70	68,371.09
7	Бусад нийтлэг төлбөр, хураамж	113,875.20	8,534.50
8	Газрын төлбөр	115,644.28	51,862.15
9	Байгалийн нөөц ашигласны төлбөр	2,140.23	7,974.45
10	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	452,548.87	1,420,138.78
11	Нийтлэг татварын бус орлого	452,548.87	213,405.07
12	Тусламжийн орлого	-	1,131,733.71
13	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	75,000.00
14	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,229,059.45	-

15	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,993,237.88	1,890,068.48
16	УРСГАЛ ЗАРДАЛ	1,993,237.88	1,890,068.48
17	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,934,038.44	1,875,288.33
18	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	972,168.97	1,083,863.93
19	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	139,541.13	120,101.97
20	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	454,148.92	482,013.68
21	Хангамж, бараа материалын зардал	80,946.79	58,936.70
22	Нормативт зардал	1,000.00	-
23	Эд хогшил, урсгал засварын зардал	27,161.65	35,625.17
24	Томилолт, зочны зардал	5,896.20	7,267.14
25	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	46,345.48	47,298.11
26	Бараа үйлчилгээний бусад зардал	206,829.30	40,181.64
27	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	59,199.44	14,780.15
28	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	632,894.16	238,686.94
29	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	438,999.77	232,866.03
30	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	438,999.77	232,866.03
31	Дотоод эх үүсвэрээр	438,999.77	232,866.03
32	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(438,999.77)	(232,866.03)
33	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	193,894.39	5,820.91
34	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	293,965.26	487,859.65
35	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	487,859.65	493,680.55

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,310,321,800.00</b>	<b>1,920,535,876.25</b>	<b>(389,785,923.75)</b>	<b>83.13</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,879,792,800.00</b>	<b>1,691,664,842.25</b>	<b>(188,127,957.75)</b>	<b>89.99</b>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,857,719,600.00	1,676,884,692.27	(180,834,907.73)	90.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,027,000,300.00	979,721,972.44	(47,278,327.56)	95.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	134,040,400.00	120,101,972.66	(13,938,427.34)	89.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	464,163,900.00	436,313,614.43	(27,850,285.57)	94.00
2104	Хангамж, бараа материалын зардал	51,508,000.00	31,142,340.00	(20,365,660.00)	60.46
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	60,130,800.00	39,620,170.00	(20,510,630.00)	65.89
2107	Томилолт, зочны зардал	11,045,000.00	7,267,136.00	(3,777,864.00)	65.80
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	58,168,000.00	24,535,850.74	(33,632,149.26)	42.18
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	51,663,200.00	38,181,636.00	(13,481,564.00)	73.90
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>22,073,200.00</b>	<b>14,780,149.98</b>	<b>(7,293,050.02)</b>	<b>66.96</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	8,481,200.00	8,481,149.98	(50.02)	100.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,592,000.00	6,299,000.00	(7,293,000.00)	46.34
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>250,000,000.00</b>	<b>228,871,034.00</b>	(21,128,966.00)	<b>91.55</b>
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	180,529,000.00	-	(180,529,000.00)	-
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	2,310,321,800.00	2,044,676,752.25	(265,645,047.75)	<b>88.50</b>
	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,220,680,000.00	1,957,918,144.25	(262,761,855.75)	<b>88.17</b>
	ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГААС САНХҮҮЖИХ	75,000,000.00	75,000,000.00	-	<b>100.00</b>
	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС САНХҮҮЖИХ	14,641,800.00	11,758,608.00	(2,883,192.00)	<b>80.31</b>
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1	1	-	100.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2	-	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	29	27	-	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	29	29	-	100.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/

Дансны код	Дансны нэр, төрөл	Тайлант он
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	13,480,506.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13,480,506.7
122	Тусламжийн орлого	13,480,506.7
1221	Хандив тусламж /дотоод/	13,480,506.7
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,480,506.7
350013	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,964,389.7
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,285,117.0
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,231,000.0
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	11,869,506.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,869,506.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,869,506.7
2104	Хангамж, бараа материалын зардал	9,104,616.7
210401	Бичиг хэрэг	220,000.0
210402	Тээвэр, шатахуун	8,304,616.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	180,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	400,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	764,890.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	764,890.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.0
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	1,611,000.0
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-1,611,000
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-1,611,000

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

---

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Зүүнбүрэн сумын ТТЗ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн ХХС-ийн зээлийн авлага болон тус ТТЗ-ийн харьяа байгууллагуудын үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Баасансүрэн гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ц.Отгонбаяр, дарга, тэргүүлэх аудитор Б.Батмөнх нар тус тус хэрэгжүүлсэн.

Зүүнбүрэн сумын ТТЗ нь 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 01/60 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын 1,735,782.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу **17,357.8** мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Тайлант онд хийгдсэн бүтцийн өөрчлөлтөөс шалтгаалан сумын ИТХ-ын тогтоолоор үүсгэн байгуулагдсан “Илдэн бүрэн” ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайлан тус суманд нэгтгэгдсэн тул гүйцэтгэлийн үеийн материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардлын 3,129,026.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцож, **31,290.3** мянган төгрөгөөр тогтоолоо.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Зүүнбүрэн сумын ТТЗ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Төсвийн байгууллагад ном хэвлэлийн зардал, дүрэмт хувцас худалдаж авахгүй байх, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл бэлдэхгүй байхад хяналт тавьж ажилласан,
- Албан хэрэг хөтлөлтийг цахимжуулж бичиг хэргийн зардлыг бууруулсан,
- Хөрөнгө оруулалтаар авто машин, шаардлагагүй тоног төхөөрөмж, тавилга худалдан аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй хамаарах 35 шалгуур үзүүлэлтийн дагуу горим, сорилыг гүйцэтгэж, холбогдох баримтыг тулган баталгаажуулахад дараах зөрчлүүд илэрч, байгууллагын хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна. Үүнд:

1. Сумын ИТХ-ын нарийн бичгийн даргын 2025 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн А/40 дүгээр тушаалаар бараа үйлчилгээний бусад зардлаас ахмадын баярын арга хэмжээнд зориулж 320.0 мянган төгрөгийн 10 шил архи худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийн үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.7 дахь “байгууллагын төсвөөр **согтууруулах ундаа худалдан авах**” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

2. “Илдэн бүрэн” ОНӨААТҮГ-ын захирлын 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/02 дугаар тушаалаар цагаан сарын баярыг тохиолдуулан байгууллагын нийт ажилтнуудад гарын бэлэг (хэвийн боов, сүү, чихэр) өгөхөд 2,538.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийн үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3 дахь “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр **тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох**”, 15.1.5 дахь “... байгууллагын хөрөнгөөр **бэлэг дурсгалын зүйл худалдан авах**” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэх.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

##### Хүснэгт 11. Шилэн данс

Д/д	Байгууллагын нэр	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн	Хугацаа хоцроосон	Мэдээлээгүй
1	Төсвийн төвлөрүүлэн захирагч	181	181	-	-
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	183	182	1	-
3	Засаг даргын Тамгын газар	183	180	3	-
4	Хоршоо хөгжүүлэх сан	183	183	-	-
5	Орон нутгийн хөгжлийн сан	183	183	-	-
	<b>Нийт дүн</b>	<b>913</b>	<b>909</b>	<b>4</b>	<b>-</b>

Эх сурвалж: [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn)

Тус ТТЗ-ийн түвшинд нийт мэдээлбэл зохих 913 мэдээллээс 909 мэдээллийг хугацаанд нь, 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг мөрдөж, шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж үзлээ.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Тайлант онд “Илдэн бүрэн” ОНӨААТҮГ нь шууд худалдан авах босго үнээс давсан 27,776.6 мянган төгрөгийн нүүрсний худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх “Захиалагч ... төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна”, 31.1.2 дахь “харьцуулалт”, Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар”-ын 1 дэх “Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар Бараа (сая.төгрөг) 20.0” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нүүрсний худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж байх албан шаардлага хүргүүлэв.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2025 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 433 дугаар “Санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар тогтоосон төлбөрийн акт, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан болон гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлээгүйгээс авлага үүсгэсэн зэрэг нийт 21,930.9 мянган төгрөгийн 5 зөрчилд албан шаардлага, 2 зөрчилд зөвлөмж өгснийг нотлох баримттай тулган баталгаажуулахад бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 11. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	3,000.0	1	3,000.0	100.0
Албан шаардлага	5	21,930.9	5	21,930.9	100.0
Зөвлөмж	2	-	2	-	100.0
Хариуцлага тооцох албан шаардлага	1	-	1	-	100.0
<b>Нийт дүн</b>	<b>9</b>	<b>24,390.9</b>	<b>9</b>	<b>24,390.9</b>	<b>100.0</b>

## 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагналтай холбоотой асуудлуудыг бүрэн хэмжээгээр тулган баталгаажуулсан боловч цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас төлөвлөлт, гүйцэтгэл, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлуудыг санхүүгийн тайлангийн аудитад бүрэн хамруулах боломжгүй байлаа.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт **135,813.0** мянган төгрөгийн алдаа илэрч аудитын явцад залруулсан. Үүнд:

- “Илдэн бүрэн” ОНӨААТҮГ-ын хөрөнгөд бүртгэлтэй халуун усны барилгад сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 74,870.7 мянган төгрөгийн их засвар хийгдсэнийг ЗДТГ-ын барилга байгууламж дансанд орлогоор бүртгэсэн,
- Сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 60,000.0 мянган төгрөгийн 10 толгой бух худалдан авсныг ЗДТГ-ын бусад үндсэн хөрөнгөд бүртгэсэн,
- Сумын ЗДТГ нь төрийн захиргааны албан хаагчийн 5 жилийн мөнгөн тэтгэмжийн ХХОАТ 942.3 мянган төгрөгийг суутган тооцсон боловч татварын дансанд шилжүүлээгүй зэрэг.

Аудитаар нийт **39,088.4** мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрч, 4,373.8 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 34,714.6 мянган төгрөгийн 5 зөрчилд албан шаардлага, сахилгын шийтгэл ногдуулах 1 албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүлэв.

Нийт илрүүлсэн **39,088.4** мянган төгрөгийн залруулагдаагүй материаллаг зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 7,798.1 мянган төгрөгөөр давсан тул “**Хязгаарлалттай**” дүгнэлт өглөө.

## 5.1 Төлбөрийн акт

1. Сумын Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн Б/18 дугаар захирамжаар ой хээрийн түймрийн үед ажилласан гэх үндэслэлээр тогтоосон хувь хэмжээнээс хэтрүүлэн, илүү цагийн нэмэгдэл хөлсөнд 4,053.8 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “*Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”-ын 3 дахь “... нэмэгдэл хөлс тооцох цаг нь энэ журмын 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн **10 хувиас хэтрэхгүй байна**” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү цагийн нэмэгдэл хөлсийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

## 5.2 Албан шаардлага

Тайлант онд “Илдэн бүрэн” ОНӨААТҮГ-т нийт 4,400.0 мянган төгрөгийн дараах 4 зөрчил илэрлээ. Үүнд:

1. Зүүнбүрэн сумын ИТХ-ын 2025 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 05 дугаар тогтоолоор баталсан тус газрын бүтэц, орон тоонд батлагдаагүй цахилгаанчны ажлыг хавсран гүйцэтгүүлсэн гэх шалтгаанаар жолоочид 40 хувийн нэмэгдэл цалин буюу 4,400.0 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх “*Захирал дараах эрх, үүрэгтэй*”, 20.1.4 дэх “... эрх бүхий байгууллагын тогтоосон цалингийн сангийн хэмжээнд багтаан цалинг тогтоох”, сумын ИТХ-ын 2021 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 26 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот Илдэн бүрэн үйлдвэрийн газрын дүрэм”-ийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх “*Илдэн бүрэн үйлдвэрийн газрын эрх барих дээд байгууллага нь сумын ИТХ байна*”, 7.4 дэх “*Илдэн бүрэн үйлдвэрийн газрын бүтэц, орон тоо, цалин хөлсний норм нормативыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар тогтоох ...*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Сумын ИТХ-аас тогтоосон бүтэц, орон тоог мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

2. Үйлдвэрийн газрын үйл ажиллагааг зохистой удирдаагүй, санхүүгийн байдалд дүн шинжилгээ хийж, бодлого менежментийг зөв тогтоогоогүйгээс 387,060.1 мянган төгрөгийн алдагдалтай ажиллаж, өөрөө өөрийгөө санхүүжүүлж чадахгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь *“Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэнэ”* гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үйл ажиллагааныхаа орлогоор өөрийгөө санхүүжүүлж чадахгүй, ихээхэн хэмжээний алдагдалтай ажилласан тус газрын асуудлыг сумын ИТХ-аар хэлэлцүүлэх, улмаар татан буулгах арга хэмжээ авах албан шаардлага хүргүүлэв.

3. Аймгийн Орон нутгийн өмчийн газрын зөвшөөрөлгүйгээр тус газрын захирал нь байгууллагын эзэмшлийн 120 мкв талбай бүхий “Халуун ус”-ыг Зүүнбүрэн сумын иргэнд түрээслэхээр 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдөр гэрээ байгуулсан байна.

Энэ нь Сэлэнгэ аймгийн ИТХ-ын 2014 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 25 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх *“Орон нутгийн өмчийг түрээслэхэд аймгийн Өмчийн албаны зөвшөөрлийг үндэслэн орон нутгийн өмч эзэмшигч хуулийн этгээд ... байгуулна”*, 2.4 дэх *“Орон нутгийн өмчийг түрээсээр эзэмшүүлэх гэрээг Орон нутгийн өмчийн албаар хянуулж батлуулсны дараа уг гэрээ хүчин төгөлдөр болно”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журмыг мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлэх.

4. Аймгийн ХХҮГ-аас хийсэн шалгалтаар уурын зуухны галч нарыг тогтоосон хэмжээнээс хэтрүүлэн илүү цагаар ажиллуулсан зөрчилд 750.0 мянган төгрөгийн торгууль ногдуулсан бөгөөд зөрчил гаргасан тус ОНӨААТҮГ-ын захирал Д.Оюунсүрэнд хариуцлага тооцолгүйгээр байгууллагын хөрөнгөөс төлж, үр ашиггүй зардал гаргасан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 Захирал дараах эрхтэй: 5-д *“Захирлын гэм буруутай үйл ажиллагаа болон энэ хууль, гэрээнд заасан эд хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хэтрүүлэн буюу урвуулан ашиглах зэргээр тухайн үйлдвэрийн газарт хохирол учруулсан бол уг хохирлыг захирал өөрийн хувийн өмчийн эд хөрөнгөөр бүрэн хариуцна”* гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил гаргасан “Илдэн бүрэн” ОНӨААТҮГ-ын захирал Д.Оюунсүрэнд **сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага** хүргүүлэв.

## **5.3 Зөвлөмж**

### **1. Авлагатай холбоотой асуудал:**

1.1. Илрүүлэлт: Хоршоог хөгжүүлэх сангийн нийт 12,417.6 мянган төгрөгийн авлагын 85.4 хувьтай тэнцэх буюу 10,609.4 мянган төгрөг нь 2011-2013 оны хооронд олгосон хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн авлага байна. Үүнээс 2016-2021 оны хооронд 3 зээлдэгч нас барсан бөгөөд тухайн үед хөрөнгө барьцаалаагүй, хамтран зээлдэгчгүйгээр зээл олгосноос шалтгаалан нийт 9,487.9 мянган төгрөг (С.Түмэнгэрэл 5,085.1 мянган төгрөг, С.Должин 3,033.2 мянган төгрөг, Д.Отгондалай 1,369.6 мянган төгрөг) -ийн зээлийн авлагыг барагдуулах боломжгүй нөхцөл байдал үүссэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь “*Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “*Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах ....*” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Дээрх 3 иргэнтэй холбоотой зээл, хүүгийн авлагыг барагдуулах арга хэмжээг дээд шатны төсвийн захирагч болон хууль хяналтын байгууллагатай хамтран хэрэгжүүлэх.

### **2. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал:**

2.1. Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 29 нэр төрөл (Сумын ИТХ нь 16,921.0 мянган төгрөгийн 3, ЗДТГ нь 74,280.5 мянган төгрөгийн 5, “Илдэн бүрэн” ОНӨААТҮГ нь 226,276.5 мянган төгрөгийн 21) -ийн хөрөнгийг актлах болон цаашид ашиглах эсэх саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлж шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2 дахь “*... элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох*” гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ өртгөө нөхсөн, ашиглаж байгаа үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэн шийдвэрлүүлэх, хөрөнгөд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 -д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 06 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
ЗДТГ	2	60,942.3	1	942.3	1	60,000.0	2	60,942.3	-	-	-	-
Илдэн бүрэн ОНӨААТҮГ	1	74,870.7	1	74,870.7	-	-	1	74,870.7	-	-	-	-
<b>ТТЗ-ийн дүн</b>	<b>3</b>	<b>135,813.0</b>	<b>2</b>	<b>75,813.0</b>	<b>1</b>	<b>60,000.0</b>	<b>3</b>	<b>135,813.0</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ИТХ	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
ЗДТГ	1	4,053.8	1	4,053.8	-	-	-	-	-	-	-	-
Илдэн бүрэн ОНӨААТҮГ	1	4,400.0	-	-	2	4,400.0	-	-	-	-	-	-
Хоршоо хөгжүүлэх сан	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
ТТЗ	2	-	-	-	1	-	-	-	1	1	-	-
<b>ТТЗ-ийн дүн</b>	<b>8</b>	<b>8,453.8</b>	<b>1</b>	<b>4,053.8</b>	<b>3</b>	<b>4,400.0</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
Шилэн дансанд 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	1	-	-	-	-	-	1	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>
<b>Бусад хууль тогтоомжийн хэрэгжилт</b>								
“Илдэн бүрэн” ОНӨААТҮГ нь шууд худалдан авах босго үнээс давсан нүүрсний худалдан авах худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй	1	27,776.6	-	-	1	27,776.6	-	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>27,776.6</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>27,776.6</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой</b>								
Сумын ИТХ нь төсвийн хөрөнгөөр архи худалдан авсан	1	320.0	1	320.0	-	-	-	-
“Илдэн бүрэн” ОНӨААТҮГ нь ажилтнуудад гарын бэлэг худалдан авсан	1	2,538.0	-	-	1	2,538.0	-	-
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>2,858.0</b>	<b>1</b>	<b>320.0</b>	<b>1</b>	<b>2,538.0</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>ТТЗ-ийн нийт дүн</b>	<b>4</b>	<b>30,634.6</b>	<b>1</b>	<b>320.0</b>	<b>2</b>	<b>30,634.6</b>	<b>1</b>	<b>-</b>

